



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/177

Чойр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн “Аймгийн 2022 оны төсөвт зохицуулалт хийх тухай” 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 оны аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар “Орон нутгийн өмчийн байгууллагуудын их засварын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Болд-Эрдэнэ  
(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Б.Ганбаяр  
(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга)

М.Долгормаа  
(Сүмбэр сумын Хөрөнгө оруулалт, эдийн засгийн төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Хөндлөнгийн төлөөлөл:

Ө.Наранчулуун  
(Сүмбэр сумын 3 дугаар багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:

Г.Энххишиг  
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаж, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ